

**“СКАЙМЕДИА КОРПОРАЦИ” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /РАО/**

Энэхүү баримт бичгээр Телевизийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах Холболтын гэрээний нөхцөлийг тодорхойлсон ба Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дах хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

“СКАЙМЕДИА КОРПОРАЦИ” ХХК нь олон суваг дамжуулах үйлчилгээг **13200003** тоот тусгай зөвшөөрөлтэйгээр Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт, Дорноговь - Замын-Үүд, Сайншанд, Сэлэнгэ - Зүүнхараа, Сүхбаатар, Хөтөл, Сүхбаатар, Өмнөговь - Ханбогд аймаг, сумдад тус тус хүргэдэг.

1. Сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага

Телевизийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт (PAL)	[SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.]
	[HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.]
Дууны оролт	[Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)]
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дэлгэцийн харьцаа	[4:3, 16:9]
SD нягтрал /пикселийн тоо/	[SD-SDI 576@50i MPEG2 гэх мэт]
HD нягтрал /пикселийн тоо/	[HD-SDI, 1080@50i, шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264) гэх мэт]
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	[Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, EBU R128, эгшин зуурын утга нь ±1 байна.]
Дууны кодлол	[Стерео болон MPEG layer 1, 2, 3 , AAC, AES гэх мэт]

2. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ

- 2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн боломжит байршлуудыг дараах хүснэгтэд харуулав.
- 2.2 Орон нутаг болон Улаанбаатарт байрлахаас үл хамааран Телевизийн зааглах цэг нь дараах байдалтай байна.

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)
Байршил 1: Телевиз Скаймедиагийн сүлжээний шилэн кабелийг ашиглан эфирээ дамжуулах тохиолдолд зааглах цэг телевизийн байран дахь нэвтрүүлэх төхөөрөмжийн гаралт дээр байрлана.
Байршил 2: Телевиз өөрсдийн шилэн кабелийг ашиглан эфирээ дамжуулах тохиолдолд зааглах цэг Скаймедиагийн байранд байрлана.

- 2.3 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студиас зааглах цэг хүртэлх сүлжээг (сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэрэг) хариуцна.
- 2.4 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэгийг дээр зааснаас өөр цэгт тогтоох саналтай бол хүсэлтийг албан бичигтээ тодорхой дурдаж, техникийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ирүүлнэ. Хэрвээ тус зааглах цэг нь Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын Хавсралт 4-д зааснаас өөр газарт байрлах бол албан бичгийн хувийг Зохицуулах хороонд илгээж, шийдвэрлүүлнэ.
- 2.5 Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

	Телевиз талд	Дамжуулагч талд (ОСДҮЭ)
Холболтын байгууламжийн төрөл	Playout server	ENCODER
Дамжуулах /нягтруулах төх/ байгууламжийн төрөл	3G/HD/SD-SDI fiber TRANSMITTER	3G/HD/SD-SDI fiber RECEIVER
Холбох шугамын төрөл, тоо	1 core fiber optic cable	1 core fiber optic cable
Холболтын интерфэйс	3G/HD/SD-SDI	3G/HD/SD-SDI


Transmitter, receiver-н мэдээлэл:

№	TX/RX	Үйлдвэрлэсэн улс	Encoder	Үйлдвэрлэсэн улс
1	Dover	China	DVEO stream	United States
2	Dotack	China	Harmonic ELC8140 AVC	United States
3	Estvision	Japan	Xinzhi	China
4	Korea media	Korea	Estvision	Japan
5	Black magic	Australia		
6	Xinzhi	China		

- 2.5.1 Телевиз өөрийн хөрөнгөөр дамжуулагчийн шаардлагад нийцсэн transmitter, receiver-г ханган ажиллаж, анхны холболтын төлбөрөөс transmitter, receiver-н дүнг хасаж тооцоо нийлэх боломжтой.

2.6 Холболтын схем, зураглал

- 2.6.1 Телевиз Скаймедиагийн сүлжээний шилэн кабелийг ашиглан эфирээ дамжуулах тохиолдолд зааглах цэг телевизийн байран дахь нэвтрүүлэх төхөөрөмжийн гаралт дээр байрлана.



Зураг.А

2.6.2 Телевиз өөрсдийн шилэн кабелийг ашиглан эфирээ дамжуулах тохиолдолд зааглах цэг Скаймедиагийн байранд байрлана.




Зураг.Б

3. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Холбогдох дугаар
Мэргэжилтэн	Г.Гэрэлчимэг	90005599

Гэрээ хийх процесс:



4. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл

Сүлжээнд холбогдох анхны холболтын хураамж

Холболт	Холболтын хураамж		Төлбөрийн төрөл
	Нөхцөл 1	Нөхцөл 2	
SD эсхүл HD анхны холболт	33,000,000₮	15,000,000₮	Нэг удаагийн
SD-ээс HD шилжих холболт	33,000,000₮	15,000,000₮	

Нөхцөл 1: Бүх төхөөрөмж орсон дүн.

Нөхцөл 2: Transmitter болон receiver төхөөрөмжийн үнэ ороогүй дүн.

Телевизийн суваг дамжуулах сарын хураамж

Телевизийн суваг дамжуулах сарын хураамж нь дараах нөхцөлийн дагуу байна.

Зааглах цэгийн байршил	Сарын хураамж
Зураг.А	500,000₮
Зураг.Б	300,000₮

Зааглах цэгийн байршлаас хамаарч дараах төлбөрийн задаргаатай байна.

Зардлын нэр	Зааглах цэгийн байршил	
	Зураг.А	Зураг.Б
Шилэн кабелийн CORE түрээс*	200,000₮	-
Холболтын төхөөрөмж, сүлжээний хяналт	200,000₮	200,000₮
Холболтын ашиглалт засвар, үйлчилгээний зардал	100,000₮	100,000₮
Нийт	500,000₮	300,000₮

*Телевиз орон нутагт байгаа болон шилэн кабелийн дэд бүтэцгүй байршилд байгаа тохиолдолд шилэн кабелийн хайгуулын үнэ төлбөр нэмэгдэж тооцогдоно.

5. Гэрээний загвар

БАТЛАВ.

“СКАЙМЕДИА КОРПОРАЦИ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

Д.НАРАНТУЯА

БАТЛАВ.

“...” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

.....

ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ, ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

20.. оны ...-р сарын ...-ны өдөр

№.....

Улаанбаатар хот

Энэхүү “Олон суваг дамжуулагчийн сүлжээнд холбогдох, харилцан холболтын гэрээ” /цаашид “гэрээ” гэх/-г Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Харилцаа холбооны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” болон холбогдох бусад журмуудыг тус тус үндэслэн,

Нэг талаас: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 9019020032 дугаарын гэрчилгээтэй, регистрийн 2619032 дугаартай “Скаймедиа Корпораци” ХХК /цаашид " Дамжуулагч" гэх/

Нөгөө талаас: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ... дугаарын гэрчилгээтэй, регистрийн ... дугаартай “...” ХХК /цаашид "Телевиз” гэх, хамтад нь “Талууд” гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Дамжуулагч нь өөрийн сүлжээ /IPTV, OTT/-нд энэ гэрээнд заасан нөхцөл шаардлагыг хангасан “...” телевизийн үйлчилгээг холбох, телевизийн сувгийг хэрэглэгчид гэрээний үндсэн дээр дамжуулан хүргэх, Телевиз нь Дамжуулагчийн сүлжээнд холбогдох, харилцан холболтын нөхцөл, шаардлагыг хангах, гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү гэрээ нь Талуудын төлөөлөл, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.
- 1.3. Мөн энэхүү гэрээний дагуу хамтран ажиллахдаа Телевиз нь бүх төрлийн нэвтрүүлэг, мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, дуу, бичлэг, уран сайхны кино, хүүхэлдэйн кино, телевизийн бүтээлүүдийг /цаашид “контент” гэх/ нийтэд түгээх эрхийг Дамжуулагчид олгож байгаа болно.
- 1.4. Энэхүү гэрээ батлагдсанаар талуудын хооронд байгуулсан ... оны ... тоот гэрээний Телевизийн үлдэгдэл төлбөр төлөхөөс бусад үүрэг дуусгавар болж байгааг талууд харилцан тохиролцов.
- 1.5. Телевизийн суваг Дамжуулагчийн сувгийн ... дугаарлалтад байршина.

- 1.6. Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хуульд зааснаар зохицуулна.
- 1.7. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, бодитоор, зохих ёсоор гүйцэтгэх бөгөөд хамтран ажиллах, харилцан туслалцах зарчмыг мөрдлөг болгоно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1. Энэхүү Гэрээг ... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс ... оны ... дугаар сарын ...-ны өдөр хүртэл 1 (нэг) жилийн хугацаатай байгуулав.
- 2.2. Гэрээний хугацаа дуусгавар болсон тохиолдолд цаашид сунгах эсэх талаар аль нэг тал нөгөө талдаа 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдэл хүлээн авсан нөгөө тал гэрээг цаашид сунгах эсэх талаар хариу өгч харилцан тохиролцож гэрээг сунгаж болно.
- 2.3. Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин 1 (нэг) жилийн хугацаагаар, ижил нөхцөлөөр жил тутам сунгагдсанд тооцно.
- 2.4. Телевиз нь талуудын ... тоот Хамтран ажиллах гэрээний ...-ны байдлаарх үлдэгдэл төлбөр болох ... /... мөнгөн дүн үсгээр/-ийг энэхүү гэрээний дагуу төлж барагдуулна.
- 2.5. Телевизийн нэвтрүүлгийг тоног төхөөрөмж рүү дамжуулах болон сигнал хүлээн авах тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, анхны удаа холбох зардал, дамжуулалтын төлбөрийг Телевиз 100% өөрийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- 2.6. Дамжуулалтын зардал, анхны холболтын хэмжээг Хавсралт №5-д тусгав.
- 2.7. Телевиз нь Хавсралт №5-д заасан анхны холболтын хураамжийг гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 3 хоногт багтаан төлж барагдуулна.
- 2.8. Гэрээний үнэд НӨАТ багтсан болно. Дамжуулагч нь телевизийг төлбөр төлөх бүрд e-баримтыг системд шивнэ.
- 2.9. Дамжуулагч нь сар бүрийн дамжуулалтын төлбөрийг Телевизээс дараа сарын эхний өдөр нэхэмжилнэ. Нэхэмжилсэн сард дамжуулалтын төлбөрийг төлөөгүй бол дараа сарын эхний өдөр Телевизийн эфирийг Скаймедиа Ай Пи ТВ-ээс хаана. Төлбөр төлөөгүйгээс шалтгаалан суваг хаах талаар дамжуулагч тал телевизэд 5 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 2.10. Телевизийн эфирийг Скаймедиа Ай Пи ТВ-ээс хаасан өдрөөс эхлэн 60 хоног өнгөрөхөд төлбөрөө барагдуулаагүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 2.11. Төлбөрийг “Худалдаа хөгжлийн” банкны 499 008 863 тоот дансанд шилжүүлнэ.
- 2.12. Төлбөр нэхэмжилсэн хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-тай тэнцэх хэмжээгээр алданги тооцно.
- 2.13. Телевиз нь нүүх буюу шинээр шилэн кабель татуулах тохиолдол бүрт шилэн кабель татуулахад гарах зардлыг тодорхойлж холбогдох нэг удаагийн ажлын хөлсийг Дамжуулагчид төлнө. Төлбөр нь нүүж байгаа байршлаас хамааран харилцан адилгүй байна.

ГУРАВ. ТЕЛЕВИЗИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Телевиз нь дараах эрхийг эдэлнэ:
 - 3.1.1. Дамжуулагчийн үзүүлж буй үйлчилгээ болон хийгдэж буй ажлууд нь чанарын шаардлага хангахгүй гэж үзвэл санал гаргах, шаардлага тавих;
 - 3.1.2. Дамжуулагчид техникийн санал, зөвлөмж өгөх эрхтэй.
 - 3.1.3. Дамжуулагчийн буруугаас телевизийн нэвтрүүлэг тасалдах, доголдох тохиолдолд дахин нэвтрүүлэх, уг зөрчлийг арилгуулахаар шаардах;
 - 3.1.4. Гэрээний үүргээ биелүүлэхийг Дамжуулагч талаас шаардах;
 - 3.1.5. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;
 - 3.1.6. Дамжуулагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар цуцлах тухай санал гаргах;
 - 3.1.7. Хуульд заасан бусад эрх;

3.2. Телевиз нь дараах үүргийг хүлээнэ:

- 3.2.1. Телевиз нь дуу дүрс дамжуулах төхөөрөмж болох HD Дамжуулагч & Хүлээн авагч төхөөрөмж /Transceiver & Receiver/ болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах;
- 3.2.2. Нэвтрүүлгийнхээ дуу дүрсний дохиог Дамжуулагчийн шаардсан техникийн нөхцөлд нийцүүлж, (Хавсралт 1)-ийг дагаж мөрдөх;
- 3.2.3. Телевиз нь өөрийн өмчийн тоног төхөөрөмжийн баталгааны хугацаа, засварын хуудсыг гэрээнд хавсаргах;
- 3.2.4. Өөрийн тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээг бүрэн хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын технологийн горимын тасралтгүй ажиллагаа, цахилгаан, зай тэжээлийн эх үүсвэрээр ханган ажиллах, хэрэглэгчдэд очиж байгаа сигналын түвшин, чанарыг шалгах, анхаарал тавих;
- 3.2.5. Дамжуулагчаас өгсөн техникийн нөхцөл, шаардлагыг хангах техник тоног төхөөрөмжтэй байх, тэдгээрийн ашиглалт үйлчилгээ хэвийн найдвартай ажиллагааг гэрээний хугацаанд тогтвортой хангаж ажиллах;
- 3.2.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд шаардагдах бусад тусгай зөвшөөрөл, лицензийг зохих журмын дагуу цаг тухайд нь эрх бүхий байгууллагаас авч, хүчин төгөлдөр байдлыг нь гэрээний хугацаанд хэвээр хадгалах;
- 3.2.7. Гэрээнд заасан хугацаанд Дамжуулагч гэрээний үүргээ хэвийн биелүүлэхэд шаардагдах бичиг баримт, мэдээллээр бүрэн хангах;
- 3.2.8. Долоо хоног бүрийн Пүрэв гарагийн 15:00 цагаас өмнө дараа 7 хоногийн телевизийн хөтөлбөрийг (erg@skytel.mn) и-мэйлээр илгээх ба илгээгдсэнээс хойш тус телевизийн хөтөлбөрт ямар нэг өөрчлөлт, хоцрогдол гарах бүрт хавсралт 4-т заасан Дамжуулагчийн контентын редактортой холбоо барих и-мэйл хаяг, утасны дугаараар цаг алдалгүй мэдэгдэх;
- 3.2.9. Телевиз техникийн үзлэг шалгалт, шинэчлэл хийх зайлшгүй шаардлага болон бусад зорилгоор хүндэтгэн үзэх шалтгаанаар эфирээ таслах буюу зайлшгүй зогсолт хийх тохиолдолд энэ тухайгаа хэрэглэгчдэд болон Дамжуулагчид заавал бичгээр болон имэйлээр 72 (далан хоёр) цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;
- 3.2.10. Дамжуулагчийн албан ёсны эрхтэй аливаа контентыг зохих зөвшөөрөлгүйгээр өөрийн сувгаар гаргахгүй байх;
- 3.2.11. Телевизийн эфирийн дүрсний чанар HD суваг бол 1920×1080 (1080i), SD суваг бол 720×576 (576i) гэсэн стандартыг хангах;
- 3.2.12. SDI embeded гаралт бүхий тогтмол -18dBFS дууны түвшинтэй байлгах;
- 3.2.13. Телевиз нь Дамжуулагчийн тоног төхөөрөмжөөр дамжин хэрэглэгчдэд очиж байгаа өөрийн контентын чанар, стандартад хяналт тавих, тэдгээртэй холбоотой аливаа хариуцлагыг бие даан хүлээх;
- 3.2.14. Холбогдох тоног төхөөрөмжүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийх;
- 3.2.15. Төхөөрөмжийн цахилгаан тэжээлийг нөөц эх үүсгүүрт холбосон байх ба багадаа 4 цаг тэжээлээр хангадаг байх. 4 цагаас илүү цахилгааны саатал гарсан бол Дамжуулагчид мэдэгдэж хэрэглэгчдэд эфир тасрах болсон талаар мэдээллийг албан ёсоор өгөх;
- 3.2.16. Үйлчилгээнд нөлөөлөхүйц техникийн үзлэг үйлчилгээ хийхээр бол 72 цагийн өмнө мэдэгдэж, Гэмтэл гарсан эсвэл техникийн үзлэг хийгдэж байгаа үед хэрэглэгчдэд мэдээлэл бүхий дүрсийг дамжуулах;
- 3.2.17. Телевизийн өөрийн техникийн саатал, үзлэг үйлчилгээний улмаас Бүтээгдэхүүн нийлүүлэхэд тасалдал гарах тохиолдолд хавсралт №1-т тусгагдсан холбоо барих мэдээллүүдийн дагуу и-мэйл хаягаар болон утсаар урьдчилан мэдэгдэх үүрэг хүлээнэ.

- Урьдчилан мэдэгдээгүйн улмаас Телевизийн хөтөлбөр доголдох, техникийн саатал гарсан тохиолдолд Дамжуулагчтай хамтран хэрэглэгчдэд албан ёсоор мэдэгдэл хийх;
- 3.2.18. Тоног төхөөрөмжтэй холбоотой өөрчлөлт, засвар үйлчилгээ хийх, дуу дүрсний чанар стандартад өөрчлөлт хийх түр зогсолт, шинэчлэл хийгдэх, байршил солих гэх мэт аливаа асуудал гарах тохиолдолд 30 хоногийн өмнө Дамжуулагчид бичгээр мэдэгдэх;
- 3.2.19. Телевиз нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас /хүний санаатай болон санамсаргүй буруутай үйлдлүүд, технологийн горим, стандартыг зөрчсөн буруутай үйл ажиллагаа гэх мэт/ Дамжуулагчид хохирол учруулбал хохирлыг бүрэн барагдуулах;
- 3.2.20. Гэрээнээс үүссэн аливаа маргаан үл ойлголцлын талаар гэрээний бус арга хэмжээ авч өөрийн давуу байдлаа ашиглан нэвтрүүлэг, мэдээ, шторк бэлтгэн ТВ-ээр цацах, Сошиал фэйсбүүк, Твиттер гэх зэрэг олон нийтийн сүлжээгээр Дамжуулагчийн ажил хэрэг, бизнесийн нэр хүндэд халдсан үйлдэл хийхгүй байх, илт худал мэдээллийг олон нийтэд тараахгүй байх;
- 3.2.21. Телевизийн ерөнхий захирал, гүйцэтгэх захирал, удирдлагын болон хуулийн этгээд өөрчлөн байгуулах замаар Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт орсон тухай бүрт 30 хоногийн өмнө албан бичгээр Дамжуулагчид мэдэгдэх ба мэдэгдсэнээр анхны холболтын хураамжийн төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй;
- 3.2.22. Телевизийн хаягын байршил, и-мэйл хаяг, утасны дугаар өөрчлөлт орох бүрт 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх;
- 3.2.23. Телевизийн хөтөлбөрийг хэсэгчлэн болон бүрэн зогсоохгүй байх, зогсоосны улмаас Дамжуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцах;
- 3.2.24. Телевизийн хөтөлбөр бэлтгэх, хүргэх үйл ажиллагаанд оюуны өмчийн хууль тогтоомжийг дээдлэх, оюуны өмчийн зөрчилтэй контентыг дамжуулахгүй байх;
- 3.2.25. Хуульд заасан бусад үүргийг хүлээнэ.

ДӨРӨВ. ДАМЖУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Дамжуулагч нь дараах эрхийг эдэлнэ:
- 4.1.1. Телевизийн эфирийг өөрсдийн тоног төхөөрөмжийг ашиглан IPTV, OTT сүлжээгээр дуу дүрсний алдагдалгүй чанарын өндөр түвшинд дамжуулах, эфирийг дахин дамжуулах
- 4.1.2. Телевизийн үзүүлж буй үйлчилгээ болон хийгдэж буй ажлууд нь чанарын шаардлага хангахгүй гэж үзвэл санал гаргах, шаардлага тавих;
- 4.1.3. Дамжуулагчийн үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах Телевизийн гаргаж өгсөн бичиг баримт, мэдээлэл болон тоног төхөөрөмж нь шаардлага хангахгүй тохиолдолд түүнийг сольж өгөх болон нэмэлт бичиг баримт гаргаж өгөхийг шаардах;
- 4.1.4. Гэрээний үүргээ биелүүлэхийг Телевизээс шаардах, гэрээний үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гэрээг дангаар цуцлах;
- 4.1.5. Байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, халдварт өвчин гарах, онц ноцтой гал түймэр дэгдэх, дайны болон онц байдал зарлахзэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсны улмаас эрх бүхий байгууллагаас үүрэг болгосны дагуу Телевизийн ямар ч нэвтрүүлгийн дундуур цаг үеийн байдлын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх;
- 4.1.6. Шаардлагатай тохиолдолд харилцан холболтын зааглах цэгийг /Хавсралт 2-д заасан/ Телевизэд 30 хоногийн өмнө мэдэгдсэнээр түүний байршлыг солих;
- 4.1.7. Дамжуулагч талын албан ёсны эрхтэй аливаа контентыг зохих зөвшөөрөлгүйгээр өөрийн сувгаар гаргахгүй байхыг Телевизээс шаардах;
- 4.1.8. Телевизийн буруутай үйл ажиллагааны улмаас Дамжуулагчид хохирол учирсан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах, нэхэмжлэх;

- 4.1.9. Дамжуулагч нь энэ гэрээний 1.5-т заасан Телевизийн сувгийн дугаарлалтыг дараах үндэслэлээр өөрчлөх эрхтэй:
 - 4.1.9.1. Дамжуулагчийн сүлжээгээр дамжиж байгаа бусад сувгууд хасагдах, нэмэгдэх;
 - 4.1.9.2. Дамжуулагч өөрийн үйлчилгээний багцад шинэчлэлт, өөрчлөлт оруулах;
 - 4.1.9.3. Телевизийн хүсэлтээр;
 - 4.1.9.4. Телевизтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр;
 - 4.1.9.5. Телевиз гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас дамжуулагчийн санаачлагаар;
 - 4.1.10. Телевиз нь гэрээний анхны холболтын хураамжийн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 90 ба түүнээс дээш хоног өнгөрсөн тохиолдолд өр авлага барагдуулах зорилгоор Зээлийн мэдээллийн тухай хууль болон Төв банк /Монголбанк/-тай байгуулсан гэрээний дагуу зээлийн мэдээллийн санд зээлийн ангиллыг бүртгүүлэх, мөн түүнчлэн хууль тогтоомжид заасны дагуу бусад арга хэмжээг авах;
 - 4.1.11. Дамжуулагчаас хамааралгүй техникийн гэмтэл, саатал гарсны улмаас тухайн суваг гарахгүй болсон тохиолдолд Телевизэд мэдэгдэж, даруй засахыг шаардах;
 - 4.1.12. Сувгаар дамжуулах хөтөлбөр, нэвтрүүлэг нь дуу, дүрс, техникийн чанар, стандартын шаардлага хангасан байхыг Телевизээс шаардах;
 - 4.1.13. Дамжуулагч нь гарч болзошгүй гэмтэл, саатлыг урьдчилан мэдсэн тохиолдолд телевизид шаардлага тавьж засуулах арга хэмжээ авах;
 - 4.1.14. Дамжуулагч нь нэвтрүүлгийн дуу дүрсний чанарын нэгдсэн үнэлгээг тогтмол хийх бөгөөд техникийн норм болон стандартад нийцэхгүй байгаа тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авахыг Телевизээс шаардана.
 - 4.1.15. Хуульд заасан бусад эрх;
- 4.2. Дамжуулагч нь дараах үүргийг хүлээнэ:
- 4.2.1. Телевизийн тусгай зөвшөөрлийн дагуу хамрах хүрээнд телевизийн сувгийг хэрэглэгчид гэрээний үндсэн дээр дамжуулан хүргэх;
 - 4.2.2. Өөрийн байранд байрлах тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээг хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын технологийн горимын тасралтгүй ажиллагаа, цахилгаан, зай тэжээлийн эх үүсвэрээр ханган ажиллах, хэрэглэгчдэд очиж байгаа сигналын түвшин, чанарт анхаарал тавина. Телевизийн буруугаас тоног төхөөрөмжид учирсан гэмтэл, эвдрэл, сааталд энэ заалт хамаарахгүй;
 - 4.2.3. Дамжуулагч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас /хүний санаатай болон санамсаргүй буруутай үйлдлүүд, технологийн горим, стандартыг зөрчсөн буруутай үйл ажиллагаа гэх мэт/ Телевизэд хохирол учруулбал хохирлыг барагдуулах;
 - 4.2.4. Сувгийн дугаарлалтыг өөрчлөх тохиолдолд Телевизэд 5 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх;
 - 4.2.5. Техник технологийн өөрчлөлт, шинэчлэл хийх /ТВ-ийг дамжуулж байгаа төхөөрөмжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх, дуу дүрсний чанар стандартад өөрчлөлт хийх/ тохиолдолд Телевизэд урьдчилан мэдэгдэж үйл ажиллагаагаа хамтран зохицуулах;
 - 4.2.6. Шилэн кабель ашиглан телевизийн олон сувгийн нэвтрүүлэг дамжуулах үйлчилгээг гэрээний хугацаанд чанартай, тогтвортой явуулж, телевизийг өөрийн үйлчилгээний багцад оруулан орон даяар дамжуулах;
 - 4.2.7. Телевизийн эфирээр цацагдаж буй мэдээ мэдээлэл болон бусад хуулиас гадуурх контентын өмнө үүрэг хүлээхгүй.
 - 4.2.8. Хэрэглэгчдэд очиж байгаа сигналыг стандарт түвшинд байлгаж чанарт анхаарал хандуулах;
 - 4.2.9. Дамжуулагч нь тоног төхөөрөмждөө үзлэг, үйлчилгээг хийх зорилгоор техникийн бүрэн зогсолтыг хагас жил тутамд тогтмол хийж байх бөгөөд энэ хугацаанд телевизийн хөтөлбөрийг дамжуулахгүй.

4.2.10. Дамжуулагч тоног төхөөрөмждөө үзлэг хийх зорилготойгоор техникийн бүрэн зогсолт хийх нь ажлын 1 өдөр хүртэлх хугацаатай байна.

ТАВ. ОЮУНЫ ӨМЧИЙН ХАРИЛЦАА

- 5.1. Телевизийн албан ёсны логог Дамжуулагч нь түүний хэлбэр дүрст ямар нэг байдлаар өөрчлөлт оруулалгүйгээр дамжуулна. Лого бараан өнгөтэй бол телевиз цагаан логотой хувилбарыг хамт өгнө.
- 5.2. Телевиз нь өөрийн албан ёсны логог стандарт хэмжээ буюу 720x540 PNG хэлбэрээр Дамжуулагчийн Epg@skytel.mn хаягаар цахим байдлаар өгнө.
- 5.3. Телевизийн албан ёсны логог Дамжуулагч нь өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээний сурталчилгаанд ашиглах эрхтэй бөгөөд ингэхдээ түүний хэлбэр дүрс, өнгө зэрэгт ямар нэг байдлаар өөрчлөлт оруулахгүйгээр ашиглана.
- 5.4. Телевиз нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан телевизийн нэвтрүүлэг, дуу, дүрс, кино зэргийг зохих зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлсэн болон үүнээс үүдэн гарах аливаа хариуцлагыг зөвхөн Телевиз бүрэн хариуцна.

ЗУРГАА. ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 6.1. Телевиз нь 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 15:00 цагаас өмнө Дамжуулагчийн epg.skytel.mn вэб хаягт нэвтрэх нэр, нууц үгээр хандаж телевизийн хөтөлбөрийг хуулна. Телевизийн хөтөлбөр болон контент тус бүрийн постер нь Хавсралт 4-д заасан 1, 2 дахь форматын дагуу, үг үсгийн алдаагүй, зөв хэмжээтэй байна.
- 6.2. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн өөрчлөлт эхлэхээс 48 цагийн өмнө epg.skytel.mn вэб хаягт хөтөлбөрийг хуулж, оруулсны дараа epg@skytel.mn и-мэйл хаяг руу өөрчлөлтийн талаарх тодорхой мэдээллийг илгээж, мэдэгдэнэ.
- 6.3. Дамжуулагчид мэдэгдэлгүй хөтөлбөрт оруулсан өөрчлөлт, хөтөлбөрийг зөрүүлснээс үүссэн аливаа гомдол, маргаантай асуудлыг Дамжуулагч хариуцахгүй.
- 6.4. Энэхүү гэрээний хүрээнд талууд харилцан мэдээлэл солилцоход дараах зарчим, дарааллыг баримтална. Үүнд:
 - 6.4.1. Нэг тал нөгөөдөө бичгээр гаргасан хүсэлтэд нөгөө тал ажлын 5 хоногийн дотор бичгээр хариу өгнө.
 - 6.4.2. Мэдээлэл солилцох холбогдох чиглэл бүрийн ажилтны мэдээллийг Хавсралт 3-д заана.
 - 6.4.3. Аль нэг талын нууц гэж үзсэн мэдээллийн нууцыг нөгөө тал хадгалах үүрэгтэй ба мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахгүй.

ДОЛОО. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 7.1. Доор дурдсан үндэслэлээр талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно. Үүнд:
 - 7.1.1. Талууд харилцан тохиролцсоноор;
 - 7.1.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас;
 - 7.1.3. Эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл бүхий мэдэгдэл ирүүлсэн;
 - 7.1.4. Телевиз нь оюуны өмчийн зөрчилтэй контентыг дамжуулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
 - 7.1.5. Гэрээнд оролцогч тал харилцан холболтын төлбөрөө төлөөгүй гэрээнд тохиролцсон боломжит хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн;
 - 7.1.6. Гэрээнд оролцогч тал цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон болон дампуурсанаа албан ёсоор зарласан;
 - 7.1.7. Компанийг татан буулгах тухай Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, эсвэл шүүхийн шийдвэр гарсан;

- 7.1.8. Гэрээ болон хуульд заасан бусад үндэслэлээр;
- 7.2. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй эсвэл удаа дараа биелүүлээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээний үүргээ биелүүлэхийг шаардсан албан бичиг хүргүүлэх бөгөөд хүргүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор гэрээний үүрэг биелэгдээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээг цуцлах тухай санал гаргаж болох ба уг саналыг бичгээр гаргана.
- 7.3. Тус гэрээний 7.1-д заасан үндэслэлээр гэрээг хугацаанаасаа өмнө цуцлахдаа нөгөө талдаа ажлын 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэн байна. Ийнхүү цуцалснаар талууд гэрээ цуцлах хүртэлх хугацааны гэрээт төлбөрийг болон бусад аливаа зардлыг төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.
- 7.4. Энэхүү гэрээний хугацаа дуусгавар болох, мөн гэрээ цуцлагдсанаар талуудад олгогдсон эрх, үүрэг мөн дуусгавар болно. Харин гэрээ зөрчсөний улаас учруулсан гэм хор арилгах, төлбөр төлөх, нууцыг хадгалах үүрэг талуудад хадгалагдана.

НАЙМ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 8.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд юуны өмнө хохирсон тал өөрийн хохирлын хэмжээг нотлох үүрэгтэй бөгөөд учруулсан хохирлоо буруутай тал нь нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.2. Учирсан хохирол гэдэгт талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас гуравдагч этгээдээс гаргасан гомдлын шаардлагыг хангахтай холбогдсон зардал, төлбөр, торгууль болон өөрт учирсан шууд болон шууд бус хохирлыг ойлгоно.
- 8.3. Үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал нь нөгөө талдаа хохирлыг нэхэмжилснээс хойш ажлын 14 хоногийн дотор нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.4. Нэвтрүүлгийн дуу дүрсний дохио удаа дараа техникийн стандарт шаардлагыг хангаагүй тохиолдолд уг нэвтрүүлгийг нэвтрүүлэхгүй байх хүртэл арга хэмжээг Скаймедиа авна.
- 8.5. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл /гал, ус, үер, газар хөдлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, ажил хаялт, локаут, үймээн, бослого, цар тахал, халдварт өвчин, нийтийг хамарсан үймээн, гуравдагч этгээдээс шалтгаалсан эвдрэл, гэмтэл гэх мэт/ буюу талуудаас үл хамаарах аливаа гэнэтийн нөхцөл байдал үүссэний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд нөгөө талдаа бичгээр 3 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 8.6. Гэрээний 8.5-д заасан нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа 30 (гуч) хоногоор хойшлогдох эсхүл хойшлогдсон тохиолдолд гэрээг цуцалж болно. Энэ тохиолдолд тухайн нөхцөл байдлын улмаас учирсан хохирол төлүүлэх, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардахгүй.
- 8.7. Талууд энэхүү гэрээний 8.5-р зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нь хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлгүй болно.
- 8.8. Телевиз нь энэхүү гэрээний 3.2-р зүйлд заасан гэрээний үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Дамжуулагчид анхны холболтын хураамжийн 30 (гуч) хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг үл маргах журмаар төлнө.

ЕС. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

- 9.1. Энэ хэсэгт Талуудын сүлжээ хоорондын харилцан холболт хийх техникийн нөхцөл, сүлжээ төлөвлөлт, зааглах цэг зэргийг тусгана.
- 9.2. **Харилцан холболт хийх техникийн үзүүлэлт**
- 9.2.1. Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсүүд, харилцан холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ын дагуу байна. Хавсралт 1-д орсон өөрчлөлтүүдийг тухай бүр тусгаж байна.
- 9.3. **Зааглах цэг**

- 9.3.1. Сүлжээний зааглах цэгүүдийн байршил Хавсралт 2-т заасны дагуу байна.
- 9.3.2. Зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг тухайн зааглах цэг байрлаж байгаа тал хариуцна.
- 9.3.3. Сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-т заасны дагуу байна.
- 9.3.4. Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцлийг хангасан байна.

АРАВ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

- 10.1. Талууд гэрээ байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах (техник, санхүү, үйлчилгээний хөлс, түүний хэмжээ, бизнесийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн болон аман хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 10.2. Талууд нөгөө талаас өгсөн мэдээллийн нууцлалыг чанд хадгалах үүрэгтэй бөгөөд нөгөө талын зөвшөөрлийг бичгээр урьдчилан авалгүйгээр олон нийтэд мэдэгдэл хийхгүй ба бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ. Нууц хадгалах үүрэг нь дараах тохиолдолд хамаарахгүй:
 - 10.2.1. Аль нэг тал нь өөрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгохыг зөвшөөрсөн;
 - 10.2.2. Нууц мэдээллийг ил болгохыг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага шаардсан;
 - 10.2.3. Компанийн тайлан тэнцлийг эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн
 - 10.2.4. Нууц мэдээллийг ил болгож байгаа Тал уг мэдээллийг нууц хадгалах мэргэжлийн үүрэг бүхий хууль зүй, татварын зөвлөгөө өгөх, аудитын мэргэжлийн этгээдэд ил болгож байгаа ба тийнхүү ил болгох нь уг Талын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай байгаа.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчлэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
- 11.2. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 11.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болох ба талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 11.4. Нэмэлт, өөрчлөлт, нэхэмжлэл, ажил хүлээлцсэн акт зэрэг нь тус гэрээний хавсралт болох бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 11.5. Талууд өөрсдийн албан ёсны хаяг болон харилцах банкны дансны өөрчлөлт, гэрээнд холбогдох үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтад гарсан аливаа өөрчлөлтийн тухай мэдээллүүдийг тухай бүр албан бичгээр мэдэгдэж байна.
- 11.6. Энэ гэрээнд заасан хугацааг хуанлийн хоногоор бодох бөгөөд талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид, хуулийн этгээдийн статус өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.
- 11.7. Гэрээг Монгол хэл дээр тус бүр нэгэн адил эрх зүйн хүчин чадалтай байх 2 /хоёр/ хувь үйлдсэн бөгөөд талууд тус бүр 1 /нэг/ хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**“СКАЙМЕДИА КОРПОРАЦИ” ХХК-ийг
төлөөлж:**

Дижитал Бүтээгдэхүүн Контент хөгжүүлэлтийн
албаны захирал

..... //

Утас:

И-мэйл:

“...” ХХК –ийг төлөөлж:

.....

..... /...../

Утас:

И-мэйл:

Дижитал Бүтээгдэхүүн Контент хөгжүүлэлтийн
хэлтсийн менежер

.....

..... //

Утас:

И-мэйл:

..... /...../

Утас:

И-мэйл:.....

Дижитал Бүтээгдэхүүн Контент хөгжүүлэлтийн
хэлтсийн мэргэжилтэн

.....

..... //

Утас:

И-мэйл:

..... /...../

Утас:

И-мэйл:.....

**ТЕЛЕВИЗИЙН ЭФИРИЙН ДАМЖУУЛАХ ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

	Телевиз	Дамжуулагч
Холболтын байгууламжийн төрөл, марк	Playout server	ENCODER
Дамжуулах /нягтруулах төх/ байгууламжийн төрөл, марк	3G/HD/SD-SDI fiber optic TRANSMITTER	3G/HD/SD-SDI fiber optic RECEIVER
Холбох шугамын төрөл, марк, тоо	1 core fiber optic cable	1 core fiber optic cable
Интерфейсийн төрөл	3G-SDI/HD-SDI/SD-SDI	3G-SDI/HD-SDI/SD-SDI

Телевизийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт (PAL)	[SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.]
	[HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.]
Дууны оролт	[Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)]
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дэлгэцийн харьцаа	[4:3, 16:9]
SD нягтрал /пикселийн тоо/	[SD-SDI 576@50i шахалтын стандарт нь MPEG2/AVC (H.264) гэх мэт]
HD нягтрал /пикселийн тоо/	[HD-SDI, 1080@50i, шахалтын стандарт нь MPEG2/AVC (H.264) гэх мэт]
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	[Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, эгшин зуурын утга нь ±1 байна.]
Дууны кодлол	[Стерео, MPEG layer 1, 2, 3 , AAC, AES гэх мэт]

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

Телевизийн студийн гаралтын дамжуулах төхөөрөмжөөс ОСДҮЭ дээр байрлах хүлээн авах төхөөрөмж хүртэлх болон холболтод ашиглагдах төхөөрөмжүүдийн мэдээллийг оруулна. Зааглах цэгээр тусгаарлан төхөөрөмжийг хамаарах талуудын дор бичнэ.


Холболтын техник, төхөөрөмжийн нэр, зориулалт	Телевиз талд	Дамжуулагч талд (ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж (Encoder) түүний төрөл, марк, сериал дугаар		SDI to IP Encoder
Дамжуулах (Tx) / Хүлээн авах (Rx) төхөөрөмж түүний төрөл марк, сериал дугаар	Tx	Rx Fiber optic convertor (Receiver, Fiber optic to SDI)
Холбох шугамын төрөл, үзүүлэлт: 1 core fiber optic гэх мэт.		1 core
Холболтын интерфэйс: HD-SDI, SD-SDI 75 Ом BNC, GbE-MPEGoIP гэх мэт өөрсдийн технологиос хамааруулан сонгож бичнэ.		3G-SDI, SD-SDI, HD-SDI 75 Ом BNC
Бусад....		

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ

Зааглах цэг байрлах хаяг	
Зааглах цэгийн байршил	1. Их засаг их сургуулийн хүрээний ... давхарт байрлах техникийн өрөө 2. Скайтел плаза өргөтгөл 2-р давхар
Тоног төхөөрөмж	- ODF - Receiver - Encoder

ХОЛБОЛТЫН ЗУРАГ

А. Телевиз Скаймедиагийн сүлжээний шилэн кабелийг ашиглан эфирээ дамжуулах тохиолдолд зааглах цэг доорх зургийн дагуу ТВ-ийн байран дахь нэвтрүүлэх төхөөрөмжийн гаралт дээр байрлана.



ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН

Дамжуулагч тал

№	Чиглэл	Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
1	Техникийн гэмтэл сааталтай холбогдолтой асуудал гарсан үед:				
2	Техникийн ашиглалттай холбогдолтой асуудал гарсан үед:				
3	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:				
4	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:				
5	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:				

Телевизийн тал

№	Чиглэл	Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
1	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:				
2	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:				
3	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:				
4	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:				

1. Скаймедиа / IPTV системд оруулах хөтөлбөрийг хүлээж авах формат /10 багана мэдээлэл/

Title/ Нэвтрүүлгийн нэр	Short summary/ мэдээлэл	Air_date/ Сар/өдөр/он	Air_time/ Эхлэх цаг	Rating/ Насны ангилал	Genre/ Төрөл	Show type/ Ангилал	Episode Name/ Цувралын нэр	Episode Number/ Анги /тоогоор/	Season number/ Улирал /тоогоор/
Жш: Оргил цаг		11/11/2019	6:00:00	PG 13	Magazine	News			
Өнөө өглөө		11/11/2019	7:00:00	G	Magazine	Entertainment			
Бяцхан оцон шувуу Пороро		11/11/2019	10:00:00	G	Animated	Movies		21	4
Миний цорын ганц		11/11/2019	10:30:00	PG 13	Soap - Melodrama	Series		51	
Хөтөч		11/11/2019	12:00:00	PG 13	Report	News			
The Voice of Mongolia	1-р хэсэг	11/11/2019	12:30:00	G	Magazine	Entertainment			
Өнөө өглөө		11/11/2019	14:00:00	G	G	Magazine	Entertainment		

**Тус бүрийн жишээ файлыг мэйлээр илгээнэ.*

2. Контент тус бүрийн poster, background хүлээн авах формат

Хэмжээ		Формат	
Хөндлөн	1920*1080	JPG	
Босоо	480*720	JPG	

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

	Төлбөрийн задаргаа	Үндэслэл, тайлбар	Төлбөрийн хэмжээ /НӨАТ-тай дүн/
1	Холболтын төхөөрөмж, сүлжээний ашиглалт, үйлчилгээний төлбөр	Тоног төхөөрөмж, систем ашиглалт үйлчилгээ, холболтын сүлжээний байнгын хяналт мониторинг /сар бүр/	...₮